



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 05 өдөр

Дугаар A/386

Булган сум

┌ Бүгд Найрамдах Солонгос Улсын Хусогийн
Их сургуулийн төлөөлөгчдийг хүлээн авахад
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймагтай хамтын ажиллагаа бүхий Бүгд Найрамдах Солонгос Улсын Хусогийн Их сургуулийн төлөөлөгчид 2025 оны 05 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд Булган аймагт ажиллахад шаардагдах 4,980,800 (дөрвөн сая есөн зуун наян мянга найман зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Наранбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР